

ҮХРИЙН НҮД

Сортын нэр: Чемпион приморья

Сортын онцлог: Эртийн сорт, Алданский виноград болон Лия плодородная сортын дундаас гаргаж авсан. Том буттай, атираа бүхий шар болон ногоон холилдсон навчтай. Том бөөрөнхий болон зуувин хэлбэрийн жимс нь исгэлэн, амтлаг. Ямар нэгэн хурц үнэргүй. Өнөдр ургацтай, хүйтэнд тэсвэртэй.



Биологийн онцлог: Биохимийн зарим судалгаанаас үзэхэд үхэрнүд нь 5-12% сахар, 3% ислэг, 2.3% органик хүчил, 1% уураг, 0.9% үнс, 0.5% пектин, 0.4% будах болон идээлэх бодисыг агуулдаг байна. Үхэрнүдний зарим сорт нь С витамин агууламжаараа нохойн хошуунаас илүү байдаг. Эрдэс бодисоос кали, натри, кальци, магни, фосфор, төмөр зонхилно.

Үхрийн нүдний ил хэсэг олон настай, модлог, гол ишгүй, бутны угийн (суурь) хэсгээс олноор гардаг. Үхэрнүдний бутны өндөр нь 1-1,5 метрээс хэтрэхгүй. Цомхон, сийрэг янз бүрийн хэлбэртэй. Бутны угаас гарсан найлзуур эхний жилдээ салаалахгүй ч хоёрдахь жилээс шинэ найлзуур үүсгэнэ. Тэдгээрийн доод талынх илүү урт байх ч дээшлэх тусам богиносно.

Үхэрнүд хавар эрт цэцэглэх цацаг багцэцэгтэй. Үүнд буй болох жимс зэрэг боловсордоггүй. Иймээс хураалт хийхдээ болцыг харгалзан үзэх зайлшгүй шаардлагатай.

Хоёрдахь жилийн намраас өсөлт, биежилт нь хэвийн богино салаанд жимслэх нахиад буй болно. Үүний дүнд хойтон жилээс нь цэцэг (багцэцэг) үзэгдэж эхлэдэг. Илүү хөгжилтэй уртавтар найлзуурт гол төлөв өсөлтийн нахиад бий болно. Оройн нахиад найлзуурын хөгжлөөс нэг их хамааралгүй ямагт өсөх хэлбэртэй (өсөлтийн нахиа) байдаг. Гэтэл жимслэх нахиа холимог байдаг онцлогтой. Иймээс ч жислэх нахиадаас багцэцэг, мөчир салаа бий болдог.

Үхэрнүд нь хүйтэнд тэсвэртэй, чийгэнд дуртай ургамал юм. Ус чийг сайтай, механик бүрэлдэхүүний хувьд хэтэрхий хүнд биш үржил шимтэй, шавранцар хөрсөнд илүү сайн ургадаг.

Үржүүлэх арга:

1. Модлог мөчрөөр үржүүлэх

Намар нэг наст салаанаас 8 см бүдүүн, 20-22 см урттай хэрчмүүд тасдан авч үхэрнүдийг модлог мөчрөөр үржүүлдэг.

1.1. Талбай засах

Суулгах талбайн хог ургамлыг цэвэрлэж, бордож боловсруулна. Энэ шед 1 м²-д 4 кг хөхөвтөр бууц хийж, 25-27 см гүн хагална. Мөчир суулгахын өмнө хөрсийг дахин сийрүүлж болно. Хөрс хэтэрхий хуурай юм уу, норсон байвал хэрчмийг хавар суулгаж болно. Энэ тохиолдолд мөчрийг доош харуулж, хөрсний төвшинөөс 7-8 см доош суулгаж ялзмагаар хучиж өвөлжүүлнэ.

1.2. Суулгах

Хавар хөрс гэсч, тариалангийн бэлтгэл ажил ид эхлэх үеэс хэрчмийг талбайдаа суулгана. Суулгах гүнийг уур амьсгалын нөхцлөөс харгалзан тогтооно. Хүнд, нойтон хөрсөнд хэрчмийг 45 градусын налуу суулгах хэрэгтэй. Сайн боловсруулсан хөнгөн хөрсөнд аль болохоор босоо суулгана. Суулгах зайг мөр хооронд 80, хэрчим хооронд 10 см-аас хэтрэхгүйгээр суулгана.

1.3. Арчлах

Хэрчим суулгасан талбайд зундаа хөрс суллах, зэрлэг зулгаах, услах зэрэг ажлуудыг чанартай гүйцэтгэх шаардлагатай. Сайтар бойжсон суулгацыг намар өөр газар шилжүүлэн суулгаж болно. Хоёр настай юм уу нэг настай ч 50 см-аас дээш урттай, 2-3 мөчир бүхий үндэс нь сайтар салаалж, 18-20 см болсон суулгацыг жишигт хүрсэн хэмээн үзнэ.

2. Мөчир дарж суулгац бэлтгэх

Үхэрнүд ургуулдаг айл өрх энэхүү аргыг түлхүү хэрэглэдэг. Энэ нь мөчир, тайрдас үндэслүүлэх боломжгүй айлд илүү тохиромжтой. Энэ зорилгоор эх ургамлаас гарсан мөчрийг түүний чигт гаргасан нарийн хувилд хийж шороогоор сайн далдалж өгнө.

3. Ногоон мөчрөөр үржүүлэх

Мөчрийг тухайн жилийн найлзуураас бэлтгэнэ. Тухайн мөчрийн амьдрах чадвар найлзуурын “болцоос” шалтгаална. Иймд мөчрийг өвслөг байдлаас модлог хэлбэрт шилжих үед бэлтгэнэ. Үүнийг найлзуурын оройн хэсгээс 8 см орчим урттай хэрчиж, дээд хэсгийн 2 навчийг талд нь хүртэл богиносгоно.

Эдгээрийг савтай усанд дүрэх юм уу нойтон хөвдөнд суулгана. Хөрс, бууцны дээд хэсгийг хуулж бага зэрэг шинэвтэр бууц нэмнэ. Дээр нь хөрс хийж гол мөрний цэвэр элсээр (4-5 см) өнгөлгө. Ногоон мөчрийн эзлэх талбайг 8х6 см-аас хэтрэхгүй байвал зохистой. Суулгаж дуусангуут жаазаа тавьж, доторх дулааныг 22-24 ° байлгана. Дарлагын дулаан 28-30° хүрэх үед жаазыг сөхөж агаарын солилцоо явуулж байх шаардлагатай.

Хөнгөр (гуалах өвчин) гарахаас сэргийлж 7-9 хоног тутам бордын шингэн (химийн бодис) шүршинэ. Суулгацаас 25-30 хоногийн дараа мөчрийн тайрсан хэсэгт калиус, үндэс үүсч эхэлнэ.

Сүүлийн хэдэн жил мөчир үндэслүүлэх ажлыг мананцар үүсгэх тусгай орчинд (хүлэмж, камер) хийх болсон. Энэ нь ажил ихээхэн хөнгөвчилж, зардлыг бууруулна. Одоогийн байдлаар Улаангом дахь ХАА-н эрдэм шинжилгээний станц, УГТЭШХүрээлэнгийн жимсний секторт тус аргыг хэрэглэж байна.

Мананжуулах төхөөрөмжтэй газар 1 м² газарт 400-550 ш суулгац бэлтгэдэг. Өсөлт түргэсгэх бодисоор боловсруулсан мөчрийг хамгаалалттай хөрсөнд мор хооронд нь 5 см, өөр хооронд 4 см зайтай (10,000/20=500 ш), 1,5-2 см гүнд суулгана. Эдгээрийг хүлэр, голын элсийг 1:1, 1:2 харьцаагаар хольж бэлтгэсэн хөрсөнд ургуулна. Хөрсийг урд өмнө нь халуун уураар ариутгаж байх ёстой. Чийгийн горимыг мананжуулагчаар зохицуулна.

Үндэс гарснаас 5 хоногийн хойно өөрөөр хэлбэл үндэс нь 2-3 см болсон суулгацыг гадагш шилжүүлнэ. Үүнийг талбайд 70x15-20 см зайтай суулгана. Эрт гаргасан суулгацыг тухайн жилийн намраас бусад газар нийлүүлж болно.

4. Бут задалж үржүүлэх

Зарим нэг сортыг өөр аймаг, сум, бусад газруудад нийлүүлэхдээ энэхүү аргыг хэрэглэдэг. Үүний тулд буцыг үндэстэй нь хамт иш бүрээр салгана. Хэсэг бүрийг суулгац болгон ашиглана.

4.1. Сорт

Нэг дор хэд хэдэн сорт ургуулахад солилцон тоос хүртэж, ургац нэмэгддэг. Буцыг өөр хооронд 1-1,25 метрээс доошгүй зайтай суулгах ч үүнийг 0,7-0,8 метр болгон ойртуулахад ургамал 2 дахь, 3 дахь жилээс жимс өгч эхэлдэг. Гэвч нэгж талбайд ургах ургамлын тоо олшруулахад ургац буурч, насжилт богиносох муу үр дагавартай.

Эрт болцтой сортоос Селечинская голлох байр эзэлнэ. Энэ нь ган хүйтэнд тэсвэртэй, томоохон жимстэй (2.9-5.5 грамм) сорт юм. Үүний нэг бут нь 3,5-4,5 кг ургац өгдөг.

4.2. Талбай бэлтгэх

Үхэр нүдийг чийг сайтай, хэт хөнгөн биш хөрстэй талбайд ургуулна. Ус нь хөрсний гадаргуун 1,5 метрээс доош байх нь зохимжтой.

Ургуулах талбайг хүрзний мөрөнд тултал гишгэж, олон наст хог ургамлын үндэслэг найлзуур, үсэрхийг сайтар цэвэрлэнэ. Бут бүрийн эзлэх талбай ургамал ургах болон арчилахад онцгой нөлөөтэй. Суулгах нүхийг 2.5x2.5, 2.5x2 м зайтай, 35-40 см өргөнтэй, 50-60 см гүн ухна.

4.3. Суулгац сонгох


15-20 см урттай, бага зэрэг модожсон, 3-5 үндэс бүхий суулгацыг ашиглаж болно. Гэмтсэн, хатсан үндсийг богиносгох юм уу бүр мөсөн авах нь зөв. Суулгацыг анх ургаж байснаас 6-8 см доошлуулж суулгана. Үүний дүнд үндэс орчмын нахиа нэмэгдэж, иш олширно.

4.4. Суулгах

Суулгацыг хавар болон намар суулгах боломжтой ч намар илүү зохимжтой. Энэ ажлыг 9 сарын сүүлээс 10 сар гартал хийнэ. Өвөлдөө бут орчмын хөрс сууж, ургамал хавар эрт сэргэнэ.

Шороо хийхийн өмнө суулгацын нүхийг хагас хувин усаар усална. Үүний $\frac{3}{4}$ -т бордоотой хольж бэлтгэсэн үржил шимт хөрс хийж өгнө. Үүндээ 1 хувин багсармал бордоо, 150 гр суперфосфат, 50 гр хүхэр хүчлийн кали юм уу 40 гр модны үнс хольж өгнө. Суулгах явцад нүхийг 2-3 удаа усална. Усалгаа хийснээс хойш суулгацыг ялзмаг, шороо, бууц, хүлэр, модны үртсийн аль нэгээр хучиж хамгаална.

Тайрах



Суулгаж дуусангуут тайралт хийж эхэлнэ. Үүгээр нэг наст найлзуур бүрт 2-4 нахиа үлдээнэ. Үүний дараагийн 2-3 жилд зөв байршилтай, илүү хөгжилтэй, 3-4 нахиа үлдээж бусдыг нь тайрна. Энэ үед сул дорой юм уу гэмтсэн салааг үлдээх хэрэггүй.

Ид жимслэх 5-7 дахь жил 10-15 ш олон наст мөчир байх ёстой. Бүтээгдэхүүн өгсөөр байгаа өтөл найлзуурын зөвхөн үзүүрийг сэрмэж болно.

Бут засч, хэлбэржүүлэх

Талбайд суулгасны дараах 2 жилээс бутны угаас гарах нэг наст найлзуурын тоог зохицуулна. Үүгээр жил бүр өсөлт, биежилт сайтай 3-4 найлзуураас бусдыг нь авч байх хэрэгтэй. Анх суулгаснаас 5-6 жилийн хойно бут бүрт янз бүрийн насны 12-15 иш байлгана. Үүнээс олон бол бут өтгөрч ургац буурдаг.

Зарим хүн хэлбэржүүлэлт хийхдээ 5-аас илүү настай найлзуур авдаг. Үүний дунд өсөлт, биежилт хэвийн, шинэ найлзуур бий болдог. Үүнээс гадна хугарсан, өвчилсөн, гэмтсэн, унжсан ишийг хөрсний төвшинд тайрна. Ямар нэг засалт, сэрмэлт хийгээгүй 8-12 настай буцыг 1-2 жилд багтаан залуужуулна. Энэ ажлыг хийх явцад бууц, эрдэс бордоо өгч бусад арчилгааг чанартай хийнэ.

Бут засч, хэлбэржүүлэх ажлыг навч унасан хойно, хүчтэй хүйтрэхээс өмнө эсвэл хавар нахиа дэлгэрэхээс өмнө амжуулах ёстой. Зуны тухайд бол гагцхүү хортонд хөнөөгдсөн иш, найлзуурыг авна.

Хөрс сийрүүлэх

Зундаа сийрүүлэлтийг 5-аас доошгүй удаа хийж, бут орчмын хөрсийг цэвэр, сийрэг байлгана. Газар дөнгөж гэсч эхлэх үеэс өнгөц сийрүүлэлт (10-аас илүүгүй) хийж эхэлнэ. Үүнийг бут орчимд 5-6 см-аас хэтрүүлэх хэрэггүй. Харин жаахан алсуур бол 10-12 см доошлуулж болно. Хучлага хэрэглэвэл чийгийн алдагдал буурч, сийрүүлэх хугацаа холдоно.

Бордох

Зөв бордож чадвал үхэрнүдний хэвийн өсөлт хангагдаж, ургац нэмэгдэнэ. Энд бууц, багсармал бордоо онцгой үүрэгтэй. Эдгээрийг хийхдээ хөрсний үржил, ургамлын насыг харгалзан үзнэ. Намар шим бордоо, фосфор, калийг бүрэн харин азотын бордоон $\frac{1}{2}$ -г хийнэ.

Нэг метр талбайг 2,5 кг бууц 20-25 гр шүвтрийн шүү, 25-35 гр суперфосфат, 10-20 гр калийн давсаар бордоно.

Хураах хүртэл ургалтын бүхий л хугацаанд нэмэгдэл тэжээл өгнө. Үүгээр нэг бутад 1-3 л бууцны шингэн өгч болно. Эсвэл 15 гр шүвтрийн шүү, 25 гр суперфосфат, 10 гр хүхэр хүчлийн кали хийнэ. Үүнийг намар оройн цагаар хэрэглэж байх нь зохимжтой. Энэ үед усалгааг тогтмол хийх хэрэгтэй.

Услах

Жимсгэний ургамлаас усыг зэгсэн шаарддаг нь үхэрнүд юм. Энэ нь зарим талаар үндэс маш өнгөц (20-30 см) тархан ургадагтай холбоотой. Усалгааг ургамлын өсөлт ид явагдаж байх үед буюу цэцэглэх, жимслэх үед голчлон хийнэ. Үүнээс гадна усалгааг хураалтын дараа ч хийнэ. Нэг бутанд 20-30 л ус зарцуулна.

Усалгааны өмнө бутыг тойруулан 20-25 см зайд, 10 см гүн суваг гаргана. Үүндээ эхний ээлжинд шингэрүүлсэн бордоогоор бордож, араас нь усалж, сувгийг тэгшилж хуурай шороогоор дүүргэнэ.

Усалгаа хийхдээ чийгийг 30-60 см гүнд хүргэх байдлаар анхаарах хэрэгтэй. Энэ тохиолдолд 1 м^2 талбайд 25-35 л ус зарцуулна.

Хортон, өвчин

Үхэрнүдний талбайд олон тооны хортон, өвчин гардаг. Иймд хортон, өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай.